ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
Энхтайваны өргөн чөлөө 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 31 17 33, Факс: (976-11) 31 38 20,
Цахим хуудас: www.pathology-center.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

2025.10.31 № 385

танай 2025.09.05 -ны № 10-00-01/003/74

Төлөвлөгөөний хэрэгжилт хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 10-00/05 дугаартай удирдамж, Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл ахуйн тухай хуулиуд болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журам, тушаал шийдвэр, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар ирүүлсэн Улсын ахлах байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 10-00-01/003/74 дугаартай албан шаардлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 22 хуудастай

Хамтын ажиллагаанд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Эмгэг судлалын үндэсний төв
Захирал
Б.Ганзориг
2025.10.31 15:02

Эрүүл мэндийн яам, Улсын ахлах байцаагчийн 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 10-00-01/003/74 дугаартай албан шаардлага хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан

Улаанбаатар хот 2025.10.29

№	Үйл ажиллагааны чиглэл	Холбогдох Монгол улсын хууль, стандарт, эрх зүйн албан бичиг	Хэрэгжүүлэх арга, зам	Хугацаа				Хэрэгжилт
				I	II	III	IV	
Нэг. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр								
1.1	Төвийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг анатомийн эмгэг судлаач эмч, лабораторийн техникчийг орон тоогоор бүрэн ажиллуулах	MNS 6676:2017 стандартын А хавсралт	Сул ажлын байрны дагуу ажилтан сонгон шалгаруулах зарыг олон нийтийн сүлжээ ба www.hr.hdc.gov.mn, www.zangia.mn сайтууд сайтууд дээр нээлттэй ил тод зарыг түгээж, хүний нөөцийн хангалт хийх	+	+	+	+	Сул ажлын байрны зарыг байгууллагын албан ёсны http://pathology-center.gov.mn/ вэб сайт болон zangia.mn, ЭМХТ-ийн HRDC сайтад байршуулан ажиллаж байгаа бөгөөд 2025 оны эхний 10 сарын байдлаар 12 ажлын байрны зарыг давхардсан тоогоор 21 удаа олон нийтэд нээлттэй ил тод мэдээлсэн. Анатомийн эмгэг судлаач эмчээр 4, лабораторийн техникчээр 3 ажилтныг шинээр томилж шаардлагатай орон

								тоонд хүний нөөцийн хангалт хийж, эмч, техникч нарын орон тоог гүйцээж ажиллалаа.
1.2	Шинэ ажилтны сонгон шалгаруулалт, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах	MNS 6676:2017 стандартын 6.4 дэх хэсэг	1.2.1 Ажилтан сонгон шалгаруулах 2025 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн А/31 дугаар “Ажилтан сонгон шалгаруулан ажилд авах” журмыг мөрдөн ажиллах	+	+	+	+	Төвийн захирлын 2025 оны А/31 тоот тушаалаар “Ажилтан сонгон шалгаруулах ажилд авах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
			1.2.2 Төвийн захирлын 2025 оны 4 дүгээр сарын 21-ны өдрийн А/24 дугаар “Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөр”-ийн дагуу ажилтнуудыг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, чиглүүлэх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтад туршилтын хугацаанд тогтмол хамруулах	+	+	+	+	Шинэ ажилтны чиглүүлэх сургалтын чиглүүлэх сургалтыг хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулан ажиллаж байгаа ба 2025 оны I, II дугаар улиралд шинээр ажилд томилогдсон 7 ажилтныг чиглүүлэх сургалтад хамруулж, тайланг УЗХ-аар 2025оны 10 дугаар 14-ний өдөр хэлэлцлээ. 2025 оны III дугаар улиралд шинээр ажилд томилогдсон 6 ажилтны чиглүүлэх сургалт 2025.10.14-2025.12.16-ны өдрийн явагдах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
1.3	Салбарын болон орон нутгийн бодлого хөтөлбөртэй	MNS 6676:2017 стандартын	Эмгэг судлалын үндэсний төвийн 2025-2028 онд хэрэгжүүлэх “Стратеги	+	+	+		Эмгэг судлалын үндэсний төвийн 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан, Эрүүл

	уялдсан стратеги төлөвлөгөөг батлуулж үр дүнг тооцож ажиллах	5.2 дах хэсэг.	төлөвлөгөө”-г боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд албан бичгээр хүргүүлж, салбарын сайдаар батлуулах					мэндийн сайдаар батлуулахаар 2025.10.16-ны өдрийн 371 тоот албан бичгээр ЭМЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.
1.4	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн алдаа, зөрчлийн гадаад шалтгааныг тогтоож, алдаа гарахаас урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах	MNS 6676:2017 стандартын 5.6, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 дугаар тушаал	1.4.1 Төвийн хэмжээнд бүртгэгдсэн тохиолдлуудын гадаад шалтгаантай тохиолдлыг түүвэрлэн, судалгаа хийх	+				2025 онд нийт 6 тохиолдол төвийн хэмжээнд бүртгэгдсэн. Тохиолдлын зэргээр ангилахад 1Б буюу анхаарал татсан нөхцөл байдал үүссэнээс үйлчлүүлэгчийн эрүүл мэнд аюулгүй байдалд нөлөөлсөн тохиолдлууд байсан. Тохиолдол бүрт тасгийн эмч тохиолдлыг бүртгэн Чанарын албанд ирүүлж тохиолдлын шалтгааныг судлахад 100% гадаад шалтгаантай буюу тухайн амьд сорьц илгээсэн байгууллага нь тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үүссэнийг тогтоосон.
			1.4.2 Судалгааны мэдээлэлд үндэслэн алдаа, зөрчил давтан гаргадаг эрүүл мэндийн байгууллага, ажилтнуудад сургалт зохион байгуулах		+			2025 оны 1 сард 3 удаагийн тохиолдлоор амьд сорьцын шинжилгээг хөлдөөж, сольж ирүүлсэн байгууллагын нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Оношилгооны зорилгоор болон мэс заслаар тайрагдсан эмгэг эд, эсийн шинжилгээг эмгэг судлалын лабораторид тээвэрлэх тухай” 1 багц

								цагийн хичээлийг ХЭСТ-ийн эрхлэгч Л.Басхүү орсон. Нийт 46 эмч, мэргэжилтэн хамрагдлаа.
			1.4.3 Тохиолдол, үл тохирлын бүртгэлийг тогтмол хөтлөх	+	+	+	+	2025 оны 10 сарын 1-ны өдрийн байдлаар гадаад шалтгаантай 1Б зэргийн 6 тохиолдол бүртгэгдсэн. ЭСҮТ-ийн Захирлын 2025 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам”-ын дагуу төвийн хэмжээнд гарсан тохиолдол бүрийг бүртгэн, дүн шинжилгээ хийж, шалтгааныг илрүүлэн, урьдчилан сэргийлж ажилласан.
			1.4.4 Улирал тутам тохиолдлын шалтгаан, давтамжийн дүн шинжилгээ хийж, давтан гарахаас сэргийлэх, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах	+			+	
1.5	Төв нь бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах	MNS 6676:2017 стандартын 5.2 дах хэсэг	1.5.1 Төвийн батлагдсан стратеги төлөвлөгөөг үндэслэн дотоод хяналт, үнэлгээний үр дүнг тооцох хяналтын хуудсыг боловсруулах			+	+	Төвийн стратеги төлөвлөгөөг боловсруулж дуусгасан бөгөөд Эрүүл мэндийн сайдаар батлуулахаар 2025.10.16-ны өдрийн 371 тоот албан бичгээр хүргүүлсэн. Стратеги төлөвлөгөө батлагдаж ирмэгц дотоод хяналт үнэлгээ хийх журмын дагуу стратегийн хэрэгжилтийг биелэлтийг хагас жил тутам хяналтын хуудас
			1.5.2 Хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцох		+		+	

			1.5.3 Хяналтын үр дүнгийн тайланг боловсруулж удирдлагын дүн шинжилгээний хурлаар танилцуулж, сайжруулах төлөвлөгөө боловсруулах		+		+	боловсруулан, хяналт үнэлгээг хийж, үр дүнгийн тайланг удирдлагын дүн шинжилгээний хурлаар танилцуулж байхаар төлөвлөн ажиллаж байна.
Хоёр. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр								
2.1	Эмгэг судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6676:2017 стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болох асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх	MNS 6392:2013 стандартын 4.2.1, MNS 6676:2017 стандартын 14.2.4 дэх заалт	2.1.1 Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг бүрэн явуулахад шаардлагатай талбайн хэмжээ, зохион байгуулалттай, стандартын шаардлага хангасан зориулалтын байртай болох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад танилцуулах		+	+	+	Төвийн үйл ажиллагааг бүрэн явуулахад шаардлагатай стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болох асуудлыг 2025.10.14-ний өдрийн 365 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд хүсэлт хүргүүлсэн. Энэхүү хүсэлтэд стандарт шаардлагад нийцсэн байрны асуудлаас гадна эд, эсийн эмгэг судлалын шинжилгээний материалыг зөөвөрлөх шаардлага хангасан хагас ачааны тээврийн хэрэгсэл хэрэгцээтэй байгаа талаар мөн дурдан албан хүсэлт илгээсэн.

			2.1.3 УНТЭ F блокийн магистраль шугам, босоо шугам, хаалт, радиаторын зураг зуруулах, засвар үйлчилгээ хийх саналыг төрийн захиргааны төв байгууллагуудад танилцуулах					УНТЭ-ийн F блокийн магистраль шугам 1971 онд ашиглалтад орсноос хойш засвар хийгдээгүй өнөөдрийг хүрсэн. Иймд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон Эмгэг судлалын үндэсний төвийн магитсраль шугамуудыг өргөтгөн шинэчлэх, босоо шугам, халаалт, радиаторуудын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн дэмжлэг хүсэх тухай хүсэлтийг 2025.09.29-ны өдрийн 345 тоот албан бичгээр ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.
2.2	Лабораторийн тасагт бохир агаарыг зайлуулж, гадна агаарыг цэвэрлэж, чийглэж оруулдаг агааржуулалтын механик болон автомат систем суурилуулан, ажлын байрны эрүүл ахуйн	MNS 6676:2017 стандартын 14.2.6 дах заалт	Лабораторийн тасагт агааржуулалтын систем суурилуулах					Агааржуулалтын тоног төхөөрөмж суурилуулах ажил үйлчилгээ гүйцэтгэгчээс үнийн санал авах зарыг ЭСҮТ-ийн албан ёсны пэйж хуудсаар 2025.08.15-ны өдөр зарлаж, гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулсан. Лабораторийн тасагт агааржуулалтын систем суурилуулагчаар “Сайн сайхан констракшн” ХХК шалгарч

	нөхцөл шаардлагыг хангуулан ажиллах							2025.09.16-ны өдөр ажил үйлчилгээг гүйцэтгэн, 2025.09.17-ны өдөр акт хүлээлгэж өгсөн.
2.3	Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллах	ЭМС-ын 2019 оны А/536 дугаар тушаалын I хавсралтын 5.1.2 дах заалт	Халдварын сэргийлэлт хяналтын багийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж төвийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллах	+				Халдварын сэргийлэлт хяналтын багийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж эмгэг судлалын тусламж, үйлчилгээний онцлогийг харгалзан үзэж 8 зорилтын хүрээнд үйл ажиллагаа төлөвлөн төвийн захирлаар 2025 оны 10 дугаар сарын 13 өдөр батуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тодотгосон төлөвлөгөө нь дараах 8 зорилтыг багтаасан болно. Үүнд: • Барилга, байгууламж орчны эрүүл ахуйн шаардлагыг хангах • Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх • Эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, хариу арга хэмжээ авах • Ажилтны эрүүл мэндийг хамгаалах • Халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах • Хог, хаягдлын менежментийг стандартын дагуу хэрэгжүүлэх • Угаалга, цэвэрлэгээний үйл ажиллагааг сайжруулах

								• Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх
.4	Шинээр ажилд авч байгаа эмч, эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл мэнд, дархлаажуулалтын нэгдсэн санг бүрдүүлэн, эмч, ажилчдын эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийн, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулан ажиллах	ЭМС-ын 2019 оны А/536 дугаар тушаалын III хавсралтын 2.3 дах заалт	2.4.1 Нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах			+		Нийт ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.8-д заасны дагуу 2025 оны III-р улиралд зохион байгуулахаар батлагдсан. Төлөвлөгөөний дагуу нийт ажилтнуудыг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг 2025.10.15-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Үзлэг, шинжилгээг Бриллиант эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн бөгөөд ажилтнууд өөрсдийн хүсэлтээр 4 төрлийн багц шинжилгээнээс сонгон хамрагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт 47 ажилтан лабораторийн болон багажийн шинжилгээнд орж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамрагдан, шаардлагатай ажилтнуудад эмчилгээ, эрүүл мэндийн зөвлөгөө авлаа.

			2.4.2 Шинээр ажилд авч байгаа эмч, эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	+	+	+	+	2025 оны 9 сарын 5-аас хойш шинээр ажилд орох ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, тус шинжилгээний хуудсыг үндэслэн 4 анатомийн эмгэг судлаач эмч, 3 лабораторийн техникчийг төвийн захирлын тушаалаар ажилд томилон ажиллуулж эхэлсэн.
			2.4.3 Улирлын томуу болон Гепатит В вирусийн эсрэг вакцинд нийт ажилтнуудыг бүрэн хамруулах, тайланг тухай бүр ХӨСҮТ рүү илгээх			+		1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 сарын 11-ний Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай А/334 дугаар тушаалын дагуу ХӨСҮТ-өөс 50 хүн тун вакцин хүлээн авч ажилтнуудыг хамруулсан. Тус төвийн нийт 59 ажилтнаас 50 хамрагдаж, хамрагдалт 84.7%. Дархлаажуулалтын мэдээг ХӨСҮТ-ийн Талбарын тархвар судлалын алба руу 2025.09.23-ны өдөр илгээсэн. МАЯГТ 3. ЭРҮҮДЛЭГ БҮЛГИЙН ХУН.ААН (Эрүүл мэндийн байгууллага) Нэр: Хамрагдах ажлын хүчин; Хамрагдсан; Хамрагдалт /%/; Эмч; Мэргэжлийн ажилтан; Сувилагч; Нарийн бичгийн дарга: 18-24; 25-29; 30-59; +65; ДДУХ. 1. Эмнэг судалгаан сэдэвтэй тай: 50; 50; 100%; 23; 11; 16; 2; 34; 14; 0 Мэдээ гаргасан:..... Э.Энхжин /Нэгдсэн, аюулгүй байдал, эсрэгдэл хариуцсан менежер/ Мэдээ зөвшөөрсөн:..... Б.Мөнх-Эрдэнэ /Нэгдсэн албаны дарга/ 2. 2025 оны 9 сарын 30-ны өдөр HBs дархлаа тогтцыг шалгах

								шинжилгээнд нийт 46 ажилтныг хамруулсан ба үүнээс дархлаа тогтсон 8 хүн, дархлаа дунд тогтсон 13 хүн, дархлаа муу тогтсон 11 хүн, дархлаа тогтоогүй 5 хүн байна. Дархлаа муу тогтсон болон дархлаа тогтоогүй 16 ажилтныг 2025 оны 11 сард багтаан дархлаажуулалтад хамруулахаар ажиллаж байна.
			2.4.4 Ажилтнуудын эрүүл мэнд, дархлаажуулалтын нэгдсэн санг бүрдүүлэх			+	+	2025 оны ЭСҮТ-ийн нийт ажилтнуудад эрүүл мэндийн үзлэг болон дархлаажуулалтад хамруулсан мэдээллийг нэгтгэн, нэгдсэн мэдээлийн санг үүсгэн, бүртгэлийн тогтолцоог сайжрууллаа.
			2.4.5 Ажилтнуудын эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй байдлын заавар, зөвлөмжийг боловсруулах			+	+	Урьдчилан сэргийлэх үзлэгийн шинжилгээний хариу болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн үр лүнг нэгтгэн, ажилтнуудын эрүүл мэндийн байдлыг үнэллээ. Үнэлгээний үр дүнг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр заавар, зөвлөмж боловсруулан, ажилтан бүрт хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2.5	Ажлын байранд гар угаах, гарын эрүүл ахуй сахих нөхцөлөөр бүрэн хангаж, гар халдваргүйжүүлэх бодисын спиртийн агууламжийг тодорхойлуулан, хэрэглээний байдалд	MNS 6392:2013 стандартын 4.2.12, ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын I хавсралтын 1.2, 1.11, II хавсралтын	2.5.1 Ажлын байранд гар угаах, гарын эрүүл ахуй сахих нөхцөлийг үнэлэх	+		+		Гар угаалтуур байрлаж байгаа хэсэг бүрт шингэн саван, зориулалтын цаасан алчуур, гар угаах санамж бүхий зурагт хуудас, гар халдваргүйжүүлэх бодисыг байрлуулсан, гарын угаалтуур байхгүй хэсгүүдэд халдваргүйжүүлэх гелийг байрлуулсан, ЭМА гартаа бөгж, бугуйвч, бугуйн цаг зэрэг гоёл чимэглэлийг хориглох санамж зурагт хуудаснуудыг байрлуулсан.
			2.5.2 Гар угаалтуурын дээр гар угаах дараалал, санамж бүхий зурагт хуудсыг бүрэн байршуулах		+		+	Эмгэг судлалын үндэсний төвд нийт 13 угаалтуур бөгөөд угаалтуур бүрийн дээр гар угаах дараалал, санамж бүхий зурагт хуудсыг бүрэн байршуулсан.

	хяналт тавьж ажиллах	4.2.4 дэх заалтууд	2.5.3 Гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ, хугацаанд хяналт тавих		+		+	Гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ, хугацаанд хяналт тавих хуудсыг шинээр боловсруулаа. Энэхүү хяналтын хуудас батлагдсаны дараа дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөн өдөр тутмын тэмдэглэл хөтлөлт хийгдэж байх болно.
			2.5.4 Нийт ажилтнуудад гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг баталгаажуулах сургалтад хамруулах		+		+	2025 оны 10 сарын 29-ны өдөр гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлагыг баталгаажуулах цахим сургалтыг зохион байгуулсан. Нийт 28 ажилтан сургалтанд хамрагдсан ба сургалтын дараа мэдлэг шалгах тестийг google forms ашиглан үнэлсэн ба 88,5%-аар үнэлэгдсэн.

2.6	Эмч, эмнэлгийн ажилтнуудад ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ажлын байранд зааврын дагуу зөв, бүрэн хэрэглэх талаар сургаж, дадлагажуулан, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшүүлэх	MNS 6676:2017 стандартын 15.3.5 дах заалт	2.6.1 Эмч, эмнэлгийн ажилтны хамгаалах хувцас, хэрэгслийн хангамж ба зарцуулалтыг тооцох	+		+		Эмгэг судлалын үндэсний төвийн хамгаалах хувцас хэрэгсэлийг хэрэглээг анатомийн эмгэг судлаач эмч болон лабораторийн техникч, технологч тус бүрээр нь хэрэглээг тооцоолон авч үзвэл: ● Эмгэг судлалын үндэсний төвд нийт 13 Анатомийн эмгэг судлаач эмч ажилладаг. Сүүлийн 9 сарын байдлаар хамгаалах хувцас хэрэгсэлийн хангаж сар бүр дунджаар 143 ширхэг хангалт  хийгдэж, зарцуулалт 102 ширхэг, үлдэгдэл 40 ширхэг байгаа нь хамгаалах хувцас хэрэгсэлийн хангамж хангалттай түвшинд байгааг харуулж байна.

								• Лабораторийн техникч, технологч нарын хамгаалах хувцас, хэрэгслийн хангамжийг 2025 оын эхний 9 сарын турш сар бүрийн хангамж болон хэрэглээг хянаж дундажлан тооцлоо. Сард хамгаалах хувцас хэрэгсэлийн хангамж 310 ширхэг, зарцуулалт 285 ширхэг, үлдэгдэл 25 ширхэг байна. Энэхүү  үнэлгээний үр дүн нь лабораторийн техникч, технологч нарт олгож буй хамгаалах хувцас, хэрэгслийн хангалт хангалттай түвшинд байгааг илтгэж байна. • 2025 оны 4 дүгээр улирлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангамжийг бүрдүүлэх зорилгоор малгай, маск, халад, улавч зэрэг шаардлагатай материалыг захиалан 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүлээн авч, хангамжийг бүрэн хангалаа.

			2.6.2 Амьд ахуйн эд, эсийн болон эмгэг судлалын шинжилгээ хийж буй эмч, эмнэлгийн ажилтны ажлын байранд хамгаалах, хувцас хэрэгслийг ашиглалтын хяналт, судалгаа хийх		+		+	Ажлын байран дахь зааварчилгааны бүртгэлийг шинэчлэн хамгаалах хувцас хэрэгсэлийн өдөр тутамын бүртгэлийг нэмэлтээр оруулсан. Ингэснээр хамгаалах хувцас хэрэгсэлийг өмсөх, тайлах дараалалыг тогтмолжуулан дадлагажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн хамгаалах хувцас хэрэгсэлийг өмсөх тайлах дараалалыг зураг хэлбэрээр эмч лаборант нарын өрөөнд байршуулсан. 
			2.6.3. Нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх зааврын тухай сургалт орох				+	2025 оны 10/29 өдөр хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах заавар бичлэг үзүүлэн XXX-ийн тухай мэдлэг олгох цахим сургалтыг хийсэн. Сургалтанд нийт 28 хүн хамрагдсан ба сургалтын дараа мэдлэг үнэлэх тестийг google form ашиглан авсан. Тестийг 28 хүн

								бөглөн 91,6%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.
2.7	Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнийг цэвэрлэх иж бүрдлийг тусламж үйлчилгээний цэг бүрд байрлуулан, шаардлагатай тохиолдолд хэрэглэх аргад суралцан, эрсдэлээс сэргийлэн ажиллах	ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын VI хавсралтын 3.1 дэх заалт	Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх багцыг ЭМС-ын А/537 дугаарын тушаалын VI хавсралтын дагуу бүрдүүлэн А бүсүүдэд байршуулах		+		+	ЭМС-ын А/537 дугаарын тушаалын VI хавсралтын дагуу А бүсүүдэд Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх багцыг бүрдүүлэн байршуулуулсан. 1. Лабораторийн хэсэгт асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх багцыг бүрдүүлэн байршуулуулсан. Хог хаягдал түр хадгалах байранд асгарсан, цацагдсан цус болон бусад органик материалыг цэвэрлэх иж бүрдлийг жагсаалт, ашиглалтын

								зааврыг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байршууллаа.  ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ **Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх багцын дутуу материалны жагсаалт** **Үндэслэл:** "Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх багцыг ЭМС-ын А/537 дугаар тушаалын VI хавсралтын дагуу бүрдүүлэн А бүсүүдэд байршуулах" гэх шаардлагын дагуу А бүсүүдэд хэрэгтэй байгаа цэвэрлэгээний материалыг аваах хүсэлт гаргах байна. Бүтээгдэхүүний нэр / Медээлэл / Нэгж үнэ / Тоо ширхэг / Нийт үнэ Том тагтай пластик сав / Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг хийх пластик сав / 45000 / 1 / 45000 Жижиг шүүр / Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэхий дараа гарах хаягдалыг цэвэрлэх шүүр болон тогтуур / 10,000 / 1 / 10000 Шингээгч цаас / Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг шингээх аваах цаас / 5000 / 1 / 5000 даавуу / Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх явцыг дараа гадаргуу цэвэрлэх алчуур / 5000 / 1 / 5000 Цэвэрлэгээний сав / Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэхий дараа гадаргуу арчих, хадгалах/ачих/ хогийг хийх сав / 10,000 / 2 / 20000
2.8	Тусламж үйлчилгээний онцлогт тохируулан цэвэрлэгээ хийх журмыг боловсруулан, цэвэрлэгээний материалыг өнгөөр ялгаж, тэмдэглэж, тасаг нэгж бүрд тусад нь хэрэглэж хэвшүүлэх	ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын VI хавсралтын 2.1 дэх заалт	2.8.1 Төвийн А, В, С бүсийн цэвэрлэгээний журам боловсруулан үйлчлүүлэгч нарт танилцуулах, сургалт зохион байгуулах	+		+		ЭСҮТ-ийн байгууллагын халдвар сэргийлэлт хяналтын журмыг шинэчлэн батлуулахаар өгсөн ба хянагдаж байна. Энэхүү журамд цэвэрлэгээний журам мөн багтсан байгаа. 2025 оны 10 сарын 29 өдөр нийт үйлчлэгч нарт журмын талаар танилцуулах сургалтыг танхимаар орсон.
			2.8.2 Цэвэрлэгээний хуудсанд хяналт хийх		+		+	Төвийн А, В, С бүсийн цэвэрлэгээ хийсэн тэмдэглэлийн хуудсан дээр хяналт хйиж 3 цэвэрлэгч тус бүрт нь

								хавтас үүсгэн, өрөө тус бүрээр хяналтыг хийж байна. ЭСҮТ-нөн лавлагаа лабораторид хялбаршуулалт хийсэн тэмдэглэл сар /№222/ Эмчилгээ /№/ Өвөр Хялбаршуулалт хийсэн аргачлал Хялбаршуулалт хийсэн талбайн хэмжээ /лугаан-ерөнд байгаа тамга хаягтайг тодорхой дурдах/ Шинэ Хадгалсан Шинэ Ашиглаж ирсэн Хүчилтөрөгчийн Чөлөөт хлор Хлорт Хлорлосон Хлорлоогүй Хялбаршуулалтыг бодисын нэр, хэрэг хэрэглэсэн Нарсыгчлах бодисын Гуулингаар хэмжих Хялбаршуулалт хийсэн арга Шүршин Ачаалж Бүтэц Хялбаршуулалтыг хийсэн огноо А-бүл 1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 Хянасан.....ЛАБЗАН Рэнжиймаа Төвийн А, В, С бүсийн цэвэрлэгээ хийсэн тэмдэглэлийн хуудсан дээр хяналт хийж 3 цэвэрлэгч тус бүрт нь хавтас үүсгэн, өрөө тус бүрээр хяналт, үнэлгээ хийлээ.
			2.8.3 Цэвэрлэгээний материалыг өнгөөр ялгах, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	+		+		Цэвэрлэгээний материалыг өнгөөр ялган, өрөө тус бүрт цэвэрлэгээнд ашиглах зааврыг боловсруулан 10 дугаар сарын 09-ний өдөр байршуулж, ажилтнуудыг зөв хэрэглэж хэвшихэд чиглэсэн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2.9	Аюултай хог хаягдлыг хадгалах өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн, эмч, эмнэлгийн ажилчдыг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэн ажиллах	ЭМС-ын 2025 оны А/193 дугаар тушаалын II хавсралтын 5 дугаар заалт	2.9.1 Төвийн А бүсэд байрлах тасаг нэгжүүдээс гарч буй ангилсан хог хаягдал нь түр хадгалах байр болон Элемент ХХК-д хүлээлгэн өгөхөөр зөөвөрлөгдөх явцдаа В болон С бүсээр дамжин өнгөрч, эрүүл мэндийн ажилтнууд болон үйлчлүүлэгчдэд халдвар дамжих эрсдэл, аюул үүсгэж байгаа тул Лавлагаа лабораторийг нэг чигийн урсгалтай болгон шаардлагатай талбайн хэмжээ, зөөвөрлөхөд хамгийн оновчтой маршрутыг тогтоож төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах		+	+		Төвийн үйл ажиллагааг бүрэн явуулахад шаардлагатай стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болох асуудлыг 2025.10.14-ний өдрийн 365 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд хүсэлт хүргүүлсэн. Энэхүү хүсэлтэд стандарт шаардлагад нийцсэн байрны асуудлаас гадна эд, эсийн эмгэг судлалын шинжилгээний материалыг зөөвөрлөх шаардлага хангасан хагас ачааны тээврийн хэрэгсэл хэрэгцээтэй байгаа талаар мөн дурдан албан хүсэлт илгээсэн. Энэхүү албан бичигт дурдагдсан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн тодорхой тооны өрөө тасалгааг манай төвд шилжүүлэн өгвөл аюултай хог хаягдал зөвөрлөх оновчтой зохион байгуулалтыг хийх боломж бүрдэх юм гэж үзэж төрийн захиргааны төв

								байгууллагад албан хүсэлт хүргүүлсэн.
			2.9.2 Эмнэлгийн аюултай хог хаягдлын стандартын шаардлага хангасан уут, сав захиалах		+		+	Элемент ХХК-с эмнэлгийн аюултай хог хаягдлын стандарт шаардлагад нийцсэн уут, савыг захиалан авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
			2.9.3 Хог хаягдлын мэргэжилтэн бэлтгэх сургалтад хамруулж, хог хаягдлын ажилтан бэлтгэх			+		Элемент ХХК-с зохион байгуулдаг эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, аюултай хог хагдлын ажилтан бэлтгэх багц цагийн сургалтад нэг ажилтнаа хамруулахаар бүртгүүлсэн бөгөөд сургалт 2025 оны 12 дугаар сард зохион байгуулагдах товлогдсон байна.

			2.9.4 Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	+			+	2025 оны 10 сарын 29 өдөр ЭСҮТ-ийн нийт ажилтнуудад эмнэлгийн аюултай хог хаягдлын тухай мэдлэг олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийт 28 ажилтан хамрагдан, сургалтын дараа мэдлэг шалгах тест авахад 81,5%-ийн үнэлгээтэй гарсан байна.
			2.9.5 Эмнэлгийн аюултай хог хаягдлын ангилах, цуглуулах, хадгалах, устгалд өгч буй үйл ажиллагаанд хяналт тавих		+		+	ЭСҮТ-ийн байгууллагын халдвар сэргийлэлт хяналтын журмыг шинэчлэн боловсруулан 2025 оны 10 сарын 22-ний өдрөөс эхлэн албаны дарга, тасаг нэгжийн эрхлэгч нараас санал авч байна. Энэхүү журамд хог хаягдлын журам хавсралтаар багтсан болно. Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах үйл ажиллагааг хянах хуудсыг боловсруулан ажиллаж байна. Энэхүү хяналтын хуудас батлагдсаны дараа дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөн өдөр тутмын тэмдэглэл хөтлөлт хийгдэж байх болно.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛЖ, НЭГТГЭСЭН:

ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕР...../Э.ЭНХЖИН/

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГА...../МӨНХ-ЭРДЭНЭ/

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ...../Б.ГАНЗОРИГ/